



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны төсвийн
гүйцэтгэлийг сонсох, 2025 оны төсвийн хуваарь батлах
зөвлөмж гаргах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8.4 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.1, 4.6, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.1, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийг сонсож, 2025 оны төсвийн хуваарийн төслийг хэлэлцээд, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны төсвийн хуваарийг батлахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад зөвлөсүгэй.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг хуваарилан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд, хэрэгжилтийг хангаж, төсвийн гүйцэтгэлийг сар бүр тайлагнаж ажиллахыг холбогдох байгууллагууд, Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН